



ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН
ХААГЧДЫН НЭГДСЭН
ЭМНЭЛЭГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр,
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41

2019.03.13 № 1324
танай _____-ны № _____-т

Тендерийн баримт бичгийг
хянасан тухай

Танайхаас зарласан “Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл худалдан авах” ӨӨ/19/001 дугаартай тендерийн баримт бичигт холбогдох гомдлыг “Ази фарм” ХХК-иас ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

Холбогдох гомдлын хянан үзэхэд захиалагч нь Тендерийн баримт бичгийн Багц-12 “Том үений гэмтэл, эмгэгийн мэс засал”-ийн Өндөр өртөгт эмнэлэгийн хэрэгсэл нийлүүлэх компанийн давхар нийлүүлэх зүйлийн жагсаалт гэж, тус жагсаалтын 1, 5, 6, 8-д тус тус заасан хэрэгслүүд нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан 2018.09.11-ний өдрийн 17 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт “Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгслийн жагсаалт”-д ороогүй, мөн жагсаалтын 9-д “Өвдөгний 100 ширхэг хиймэл үе тутамд 1 ширхэг өвдөгний хиймэл үе, нэг удаагийн хэрэгслийн иж бүрдэл дагалдуулна” гэж заасан нь төсөвт өртөгт тооцоогүй нэмэлт бүтээгдэхүүнийг шаардсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах” гэж, 46.1.5-т “тухайн бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх” гэж заасныг зөрчин тендерийн баримт бичгийг боловсруулсан байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018.09.11-ний өдрийн 17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Өндөр өртөгтэй зарим тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, зарим төрлийн хиймэл цорго, сэргээн засах зориулалтаар хийгдэх протез, ортопедийн хэрэгслийн зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх хяналт тавих журам”-ын 1.3, 1.4 дүгээр заалтад Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нь өндөр өртөгтийн хэрэгслийн худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулна” гэж заасан байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3-т “зөрчлийг арилгасны үндсэн дээр тендер шалгаруулалтыг явуулахыг захиалагчаас шаардах” гэж заасны дагуу тендерийн баримт бичгийг багц-12-ийн Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх компанийн давхар нийлүүлэх зүйлийн жагсаалтад тусгасан хэрэгслүүдийг жагсаалтаас хасч тендерийн баримт бичигтээ холбогдох өөрчлөлтийг оруулан энэ талаараа тендерт оролцогчдод болон тус газарт мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА

Б.ЛХАГВА